



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дурмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэхь хэсэг 4.2.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
- Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ



1522630219